



## ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 11 сарын 23 өдөр

Дугаар А/277

Улаанбаатар хот

Төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс, анги,  
байгууллагуудын жилийн эцсийн гамшгаас хамгаалах  
үйл ажиллагааны үр дүн, бэлэн байдлын үзлэг,  
шалгалтыг зохион байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар 8.4, 15 дугаар зүйлийн 15.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 8 дугаар зүйлийн 8.2.5, 25 дугаар зүйлийн 25.1.1, 25.2 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс, анги, байгууллагуудын 2016 оны гамшгаас хамгаалах үйл ажиллагааны үр дүн, бэлэн байдлын үзлэг, шалгалтыг зохион байгуулах ажлын хэсгийн удирдамжийг нэгдүгээр, ажлын хэсгийн бүрэлдэхүүн, үзлэг, шалгалт явуулах хуваарь, хугацааг хоёрдугаар, үзлэг, шалгалттай холбогдон гарах зардлын тооцоог гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Үзлэг, шалгалт явуулах ажлын хэсгүүдийн томилолтын зардал 6,902,000 (зургаан сая есөн зуун хоёр мянга) төгрөгийг гамшгаас сэргийлэх сургалт, сурталчилгааны зардлаас гаргахыг Санхүү, хангалт үйлчилгээний газар (онцгой байдлын хурандаа Р.Дадам)-т, шатахууны зардал 2,975,743 (хоёр сая есөн зуун далан таван мянга долоон зуун дөчин гурав) төгрөгийг зохих зардлаас гаргахыг Хангалт, үйлчилгээний анги (онцгой байдлын хурандаа С.Бямбасүрэн)-д тус тус зөвшөөрсүгэй.

3. Үзлэг, шалгалтыг удирдамжийн дагуу 2016 оны 12 дугаар сарын 08-ны дотор зохион байгуулж дуусгах, үзлэг шалгалтын ерөнхий дүнг 12 дугаар сарын 15-ны дотор Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөлийн хуралдаанд танилцуулахыг тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга (онцгой байдлын хурандаа П.Баттогтох)-д даалгасугай.

ДАРГА,  
БРИГАДЫН ГЕНЕРАЛ



Т.БАДРАЛ

000000008121

Онцгой байдлын ерөнхий газрын даргын  
2016 оны 14 дүгээр сарын 28 ны өдрийн  
А/277- дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ТӨВ, ОРОН НУТГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР, ХЭЛТЭС, АНГИ  
БАЙГУУЛЛАГУУДЫН ЖИЛИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ҮР ДҮН, БЭЛЭН БАЙДЛЫН ҮЗЛЭГ, ШАЛГАЛТЫН УДИРДАМЖ

Нэг. Зорилго:

1.1. Энэхүү удирдамж нь Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын 2016 оны гамшгаас хамгаалах үйл ажиллагааны хүрсэн үр дүн, ололт амжилтыг нэгтгэн дүгнэх, бэлэн байдлын үзлэг, шалгалтыг зохион байгуулж, шалган зааварчилгаа өгөх, тухайн газар, хэлтэс, анги, байгууллагын үндсэн ажлын гүйцэтгэл, албан хаагчдын мэргэжлийн ур чадварын түвшин, ёс зүйн төлөвшил, хандлага, цэрэгжилт, жагсаалч байдал, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах талаар болон эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр авсан арга хэмжээ, хууль тогтоомж, дүрэм журам, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх талаар хийсэн ажлын явц, үр дүн сахилга, хариуцлага, соёл хүмүүжлийн ажил, гамшгаас хамгаалах сургалт, урьдчилан сэргийлэх ажлын бодит үр дүн, гал түймрийн болон гамшгийн улсын хяналт, үзлэг, шалгалт, хүний нөөцийн "Цахим бүртгэл мэдээллийн систем"-ийн бүрдэл, офицер, ахлагчийн хувийн хэргийн баяжилт, баримт бичиг, архивын материалын хадгалалт, хамгаалалт, төсвийг үр ашигтай, зориулалтын дагуу зөв хэмнэлттэй зарцуулж ажилласан байдал, Зэвсэгт хүчинд дагаж мөрдөх "Цэргийн албан хаагчдын бие бялдрын стандарт"-ыг мөрдүүлэх, Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын 2016 оны дэвшүүлсэн зорилтын хэрэгжилтийг хангах талаарх үйл ажиллагааны үр дүн ажлын үзүүлэлтийг дүгнэхэд оршино.

Хоёр. Хамрах хүрээ:

2.1. Үзлэг, шалгалтад төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс, анги, байгууллага, Улсын нөөцийн салбарын албан хаагчид бүрэн хамрагдана.

Гурав. Үзлэг, шалгалтын зохион байгуулалт:

3.1. Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар томилогдсон ажлын хэсгийн дарга, гишүүд нь "Онцгой байдлын ерөнхий газрын харьяа салбар нэгжийн үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалт зохион байгуулах аргачлал, заавар"-ыг мөрдлөг болгон үзлэг, шалгалтыг ил тод, шударга явуулж, хамрагдсан тухайн газрын

үзлэг, шалгалтын дүнг нэгтгэн, Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөлийн хуралдаанд танилцуулна.

Дөрөв. Шалгаж үнэлэх:

Үзлэг, шалгалтын хүрээнд:

-Тухайн газар, хэлтэс, анги, байгууллагын гамшгаас хамгаалах бэлтгэл, бэлэн байдлыг шалган, зааварчилгаа өгсөн байдал;

-Тухайн газар, хэлтэс, анги, байгууллагын тухайн жилийн үндсэн ажлын гүйцэтгэл, /хуулиар хүлээсэн үүрэг, Онцгой байдлын ерөнхий газраас дэвшүүлсэн зорилт, өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэхийн тулд гаргасан төлөвлөгөө, түүний биелэлт, бодит үр дүн/

-Албан хаагчдын мэргэжлийн ур чадварын түвшин, ёс зүйн төлөвшил, хандлага, цэрэгжилт, жагсаалч байдлыг үнэлэх;

- Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах талаар болон эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр авсан арга хэмжээ, үр дүнд хүрсэн байдал;

-Хууль тогтоомж, дүрэм журам, сахилга, хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх, төлөвшүүлэх чиглэлийн сургалт, соёл хүмүүжлийн ажил, гамшгаас хамгаалах сургалт, урьдчилан сэргийлэх ажлын бодит үр дүнг шалгах; /Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Улсын нөөцийн тухай, Монгол Улсын Батлан хамгаалах тухай, Зэвсэгт хүчний тухай, Цэргийн албаны тухай, Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулиуд болон бусад холбогдох хууль тогтоомжийг сурталчлах ажлыг байнга зохион байгуулж хэвшсэн байдал, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, урьдчилан сэргийлэх ажлын үзүүлэлт/

- Тухайн газар, хэлтэс анги, байгууллагын албан хаагчдын офицер бие бүрэлдэхүүний 50 хувьд, ахлагч бие бүрэлдэхүүний 30 хувьд түүврийн аргаар сонгож тестийн аргаар шалгалт авах; /тестийн материалыг ажлын хэсэг өөрсдөө боловсруулан нууцлалтыг чандлан хадгална./

- Шалгалтын тест нь 50 асуулттай байх ба 1 асуултыг 2 оноогоор үнэлнэ. /Эрх зүйн холбогдолтой-10, мэргэжлийн холбогдолтой-20, дотоод албаны дүрэм, журам-10, англи хэл, сэтгэхүйн-10 асуултаас тус тус бүрдэнэ./

-Гал түймрийн болон гамшгаас хамгаалах улсын хяналт, үзлэг, шалгалтын талаарх авсан арга хэмжээ; /хяналтын ажлын төлөвлөгөөний биелэлт, үзлэг, шалгалт шалгалтын тоо/

-Хүний нөөцийн "Цахим бүртгэл мэдээллийн систем"-ийн бүрдэл, офицер,

ахлагчийн хувийн хэргийн баяжилт, баримт бичиг, архивын материалын хадгалалт, хамгаалалт;

- Төсвийг үр ашигтай, зориулалтын дагуу зөв, хэмнэлттэй зарцуулж ажилласан байдал;

-Зэвсэгт хүчинд дагаж мөрдөх “Цэргийн албан хаагчдын бие бялдрын стандарт”-ыг мөрдүүлэх; /албан хаагчдын бие бялдрын стандартыг тодорхойлох, илүүдэл жин, таргалттай албан хаагчдад хэвийн жинд хүрэх үүрэг өгөх/

- Батлан хамгаалахын багц хуулиудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Төв, орон нутгийн Онцгой байдлын газар, анги, байгууллагуудын албан хаагчдыг цэргийн тангараг өргөх ёслолын ажиллагааг анги, салбарт цэргийн дүрэмд тогтоосноор зохион байгуулах.

Тав. Үзлэг, шалгалтын ерөнхий дүнг гаргах:

5.1. Ажлын хэсэг нь үзлэг, шалгалтын дүнг нэгтгэж ерөнхий үнэлгээ гарган, нотломж үйлдэж, цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмжийн хамт үзлэг, шалгалт явагдаж дууссанаас хойш ажлын 5 хоногт багтаан Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөлийн хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлнэ.

5.2. Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөлөөс гаргасан шийдвэрийг төв орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс, анги, байгууллагуудад, холбогдох саналыг Захиргааны удирдлагын газарт тус тус хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

---oOo---